



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 5¹, 6¹, 6² дугаар зүйл тус тус нэмсүгэй:

1/5¹ дүгээр зүйл:

Хэвлэх

“5¹ дүгээр зүйл.Малчинд тэтгэвэр тогтоох болон тэтгэврийн насыг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг Засгийн газар батална.”

2/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан өндөр насны тэтгэврийг өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насандаа тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2038 он хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.”

3/6² дугаар зүйл:

“6² дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дараалсан хугацаа 2019 онд 6 жил, 2020 онд 7 жил, өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийн хуваагдах сарын тоо 2019 онд 72 сар, 2020 онд 84 сар байна.”

2 дугаар зүйл.1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болзлыг доор дурдсанаар тогтооно:

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас
1958	60 нас 3 сар
1959	60 нас 6 сар
1960	60 нас 9 сар
1961	61 нас
1962	61 нас 3 сар
1963	61 нас 6 сар
1964	61 нас 9 сар
1965	62 нас
1966	62 нас 3 сар
1967	62 нас 6 сар
1968	62 нас 9 сар
1969	63 нас
1970	63 нас 3 сар
1971	63 нас 6 сар
1972	63 нас 9 сар
1973	64 нас
1974	64 нас 3 сар
1975	64 нас 6 сар
1976	64 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас

2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1962 ба түүнээс өмнө	55 нас
1963	55 нас 3 сар
1964	55 нас 6 сар
1965	55 нас 9 сар
1966	56 нас
1967	56 нас 3 сар
1968	56 нас 6 сар
1969	56 нас 9 сар
1970	57 нас
1971	57 нас 3 сар
1972	57 нас 6 сар
1973	57 нас 9 сар
1974	58 нас
1975	58 нас 3 сар

1976	58 нас 6 сар
1977	58 нас 9 сар
1978	59 нас
1979	59 нас 3 сар
1980	59 нас 6 сар
1981	59 нас 9 сар
1982	60 нас
1983	60 нас 3 сар
1984	60 нас 6 сар
1985	60 нас 9 сар
1986	61 нас
1987	61 нас 3 сар
1988	61 нас 6 сар
1989	61 нас 9 сар
1990	62 нас
1991	62 нас 3 сар
1992	62 нас 6 сар
1993	62 нас 9 сар
1994	63 нас
1995	63 нас 3 сар
1996	63 нас 6 сар
1997	63 нас 9 сар
1998	64 нас
1999	64 нас 3 сар
2000	64 нас 6 сар
2001	64 нас 9 сар
2002 ба түүнээс хойш	65 нас

3 дугаар зүйл.1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД